



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/250

Эрдэнэт

Ажлын хэсэг байгуулах, хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3./б,г/, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/71 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын уул уурхайн ашиглалтын улмаас болон хууль бус үйл ажиллагаанаас болж эвдэрсэн газрын тооллого хийж, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг I, тооллого, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахад шаардлагатай зардлыг II хавсралтаар баталсугай.

2.Тооллого, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахад шаардлагатай зардал болох 8000000 /Найман сая/ төгрөгийг Байгаль хамгаалах арга хэмжээний хөрөнгө оруулалтын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т Зөвшөөрсүгэй.

3.Холбогдох хууль тогтоомжийн дагуу дээрх ажлыг шуурхай зохион байгуулж дүнг 2017 оны 06 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг Ажлын хэсэг /н.Жаргалсайхан/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
4 дүгээр сарын 28-ны өдрийн
4/250 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

**ТООЛЛОГО ХИЙЖ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын нэр төрөл	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахууны зардал	Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт 400 км 2 машинаар	л	160	1650	264000
2	Засгийн газрын 2009 оны 175 дугаар тогтоолоор хэмжилт зураглал болон суурин хээрийн боловсруулалт хийх ажлын зардал	Баян-өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт	ширхэг /Эргэлтийн цэг/	100	16593	1659300
3	Бичиг хэргийн нийт зардал: /Цаас, Хор, Хавтас/	-				76700
5	БОАЖЯамнаас Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний эрхтэй мэргэжлийн байгууллагаар эвдрэлд орсон газар тус бүр дээр экологи, эдийн засгийн хохирол болон нөхөн сэргээх ажлын зардлыг холбогдох журмын дагуу тогтоолгох ажлын зардал	Баян-өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт	га	150	40000	6000000
6	Нийт дүн					8000000